

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2019 оны 12 дугаар сарын 19

Багануур дүүрэг

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Зорилт	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Гүйцэтгэл, хувь	Үнэлгээний хувь
1	2	3	4	5	6	7	8
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ – ӨРХ БҮРД							
1.1. ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙГ ЦОГЦООР НЬ ХӨГЖҮҮЛНЭ.							
1.1.1.4 Багануур дүүрэгт “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах ажлыг эхлүүлнэ.	1.5. Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажлыг эхлүүлнэ.	1.5.1. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийг гүйцэтгүүлэн хүлээн авах БХБЯ-ны 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн №2018/10 тоот гэрээгээр Мон-Энержи Консалт ХХК Паркийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийг гүйцэтгэж 2018 оны 09 дүгээр сарын 27-нд дуусах байсан боловч хугацааг 2 удаа сунгаж хойшлуулсан. ➢ Паркийн ерөнхий төлөвлөгөөг НИТХ-аар хэлэлцүүлж батлуулсан ➢ Цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгогдоогүй ч бусад гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулагдаж БХТ-ийн магадлангаар хянагдаж байна.	БХБЯ БҮТП ОНӨТҮГ “Мон-Энержи Консалт” ХХК	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	90%	

		<ul style="list-style-type: none"> ➤ Зураг төслийн ажил удааширсан нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгогдохгүй байгаагаас болж байна. Шалтгаан нь: <ul style="list-style-type: none"> ○ Эрчим хүчний сайдын 2018 оны 133 дугаар тушаалаар цахилгаан, дулааны техникийн нөхцөл олгохыг 2018 оны 09 дүгээр сарын 25-наас эхлэн 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл түр зогсоох шийдвэр гаргасан. ○ ЭХЯ-ны холбогдох газар нь, БҮТП-ийн ТЭЗҮ-ийг гүйцэтгэгч байгууллага ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй гэсэн шалтгаанаар хойшлуулсан. ○ Мөн горимын ачааллын тооцоог Диспетчерийн үндэсний төв /ДҮТ/-өөр заавал гүйцэтгүүлэх шаардлагатай гэсэн шаардлагыг төсөл гүйцэтгэгч компанид тавьсан. ➤ Паркийн захиргаа уг асуудлыг Эрчим хүчний сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарт танилцуулснаар цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг олгох асуудлыг 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Эрчим хүчний хэрэгжилтийн Цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгох ажлын хэсгийн хурлаар БХБЯ, БХТ, Мон-Энержи Консалт ХХК, НШУУИГ, БҮТП-ийн дарга болон холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан хэлэлцэж шийдвэрлэсэн. ➤ Одоо ДҮТ нь төслийн горимын ачааллын тооцоог гаргаж, Мон Энержи ХХК нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн дагуу зураг төслийг боловсруулан дуусгаж байна. 					
	1.5.2. БҮТП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалтын асуудлыг боловсруулж дээд шатны байгууллагуудад хүргүүлэх	БҮТП ОНӨТҮГ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%			
		<ul style="list-style-type: none"> ➤ Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор МУ-ыг хөгжүүлэх 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт дэд бүтцийг байгуулах 108,7 тэрбум төгрөгийг баталсан ч санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй гээд шийдвэрлээгүй байна. 	100%				


		<p>➤ 2019 оны 02 дугаар сард уг хөтөлбөрийн тодотголоор санхүүжилтийн саналаа тусгаж шийдвэрлүүлэхээр УУХҮЯ-ны ХҮГТГ, нийслэлийн ХБТГ болон Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.</p> <p>➤ ҮХГ-аас гаргасан МУ-д 2019 онд нэн тэргүүнд шаардлагатай хөрөнгө оруулалтын 10 төслийн жагсаалтад БҮТП-ийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт орсон. Гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарт саналуудыг хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>➤ Улс, нийслэлийн 2020 оны төсөвт Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110 кВт-ын агаарын шугам, 110/35-ын 50 мВт-ын дэд станц, хүнд ба хөнгөн үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийг байгуулахад шаардлагатай 59,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгуулах саналыг ЭХЯ, БХБЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ болон нийслэлийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тус тус тавьсан.</p> <p>Дээрх газруудаас ирсэн хариу бичгийн дагуу шаардлагатай хөрөнгө оруулалтын материалуудыг боловсруулж хүргүүлснээр БХБЯ нь улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтад паркийн хөрөнгө оруулалтын саналыг тусгаж Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>➤ 2020 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт болон Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн саналд дараах санхүүжилтүүдийг шийдвэрлүүлэхээр тусгаж нийслэлийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст холбогдох материалуудын хамт хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай 59,7 тэрбум төгрөг • Нийслэлийн өмчийн харилцааны газраас паркад шилжүүлсэн хуучин конторын барилгын засварын 735,0 сая төгрөг, 			
--	--	--	--	--	--


		<ul style="list-style-type: none"> • Паркийн ургамал нанобиотехнологийн үйлдвэрлэлийн бүсийн хамгаалалтын хашаа, ойн зурвас, усжуулалтын системийг байгуулах 1000,0 сая төгрөг, • Техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх 30,0 сая төгрөг, <p>➤ 2019 онд Нийслэлийн Засаг даргын А/619 дүгээр захирамжаар паркад Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төсөл хийлгэх 65 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээр нарийвчилсан үнэлгээг “Санни трейд” ХХК-аар, барилгын зураг төслийг “Нутаг консалтинг” ХХК-иар гүйцэтгүүлж байгаа бөгөөд ондоо багтаан дуусгах гэрээтэй ажиллаж байна. Захиалагч нь зураг төсөл болон үнэлгээний тайланг хүлээн авна.</p> <p>➤ Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналуудыг дэмжүүлэхээр Монгол Улсын Их хурлын гишүүн С.Батболд, Ц.Цогзолмаа, Ц.Мөнх-Оргил, Д.Цогтбаатар болон Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлого хариуцсан нэгдүгээр орлогч дарга Ж.Батбаясгалан, Багануур дүүргийн Засаг дарга Ц.Сандаг-Очир нарт 2020 онд эхлүүлэх паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлуудыг танилцуулж, дэмжлэг хүссэн албан бичгүүдийг хүргүүлсэн.</p> <p>➤ УИХ-ын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн 4.4.4.5-д “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийг ашиглалтад оруулах” гэсэн заалтыг үндэслэн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний томсгосон тооцооны 265.81 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2020-2025 онд хэсэгчлэн тусгахаар саналаа НШУҮИГ-т хүргүүлсэн.</p> <p>➤ Дэд бүтцийн бүтээн байгуулалтын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр улс, нийслэлийн төсөвт суулгах саналыг дээд байгууллагад удаа дараалан хүргэсэн боловч шийдвэрлэгдээгүй. Тус саналд:</p>			
--	--	--	--	--	--


		<ol style="list-style-type: none"> 1. Хүнд үйлдвэрлэлийн бүсийн 20,1 тэрбум төгрөгийн санхүүжилттэй дэд бүтцийн бүтээн байгуулалтын зардлыг бууруулах, цаг хугацаа хэмнэх үүднээс Багануур ХК-ийн одоогоор ашиглалтгүй байгаа (“Породная станция”) төмөр замын хөрс тээвэрлэлтийн станцын барилга байгууламж, дэд бүтцийг ашиглах боломж байгааг судалж, саналаа 2020 оны 1-р улиралд Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахаар төлөвлөж байна. 2. Хөнгөн үйлдвэрлэлийн бүсийн 30,1 тэрбум төгрөгийн санхүүжилт 3. Паркад нэн тэргүүнд шаардлагатай ерөнхий цахилгаан хангамжийн 110 кВт-ын агаарын шугам, 110/35 кВт-ын 50 мВт-ын дэд станцийн 9,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх хүсэлтийг УУХҮЯ, БХБЯ болон нийслэлийн удирдлагуудтай паркийн дарга биечлэн уулзаж хүсэлт тавьсан! 				
	1.5.4. Эрдэм шинжилгээ, шинэ бүтээлийн судалгаа, туршилтыг явуулах, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.		БҮТП ОНӨТҮГ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	
		<ol style="list-style-type: none"> 1. Паркийн санаачилгаар “Нийслэлийн паркуудын тулгамдсан асуудал ба инновацийг хөгжүүлэх арга зам” сэдэвт уулзалт зөвлөгөөнийг НШУҮИГ-тай хамтран зохион байгуулж, “БҮТП-ийн тулгамдаж буй асуудал” болон “БҮТП-д инновацийг хөгжүүлэх нь” гэсэн сэдвүүдээр илтгэл тавьсан. Тус хуралд оролцсон ШУА, ШУТИС, ХААИС, УХЭШХ-гийн эрдэмтдийн санал зөвлөмжүүдийг хэлэлцүүлсэн. 2. Монгол Улсын Үндэсний хөгжлийн газар болон Герман улсын GIZ ЭТИС хөтөлбөрийн хэрэгжүүлэгчээс хамтран зарласан “Инноваци 2019” төсөл сонгон шалгаруулалтад паркийн зүгээс Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх, Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооноос будаг гаргах, элсээр зүлгүүр хийх, Багануур цахилгаан механикийн үйлдвэрээс гарах төмрийн хаягдал хэрчдэсээр бэлэг дурсгалын зүйл хийх, Хүүхдийн модон тоглоомын үйлдвэрүүдийн инновацийн төслүүдийг боловсруулж хүргүүлснээс эхний 2 төсөл нь үндсэн шалгаруулалтад тэнцсэн. 3. Паркад биотехнологийг хөгжүүлэх зорилт, Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Эко хот” төслийн санаачилгыг өрнүүлэн, 			100%	

		<p>үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх талаар “Багануур тохижилт” ОНӨААТҮГ-тай хамтын ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тус байгууллагын ажилтан-айл өрхөд үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх сургалтыг 5 удаа зохион байгуулж, газар дээр нь бордоо хийх бэлтгэл ажлыг хангаж 2 айлд үзүүлэх сургалт хийсэн.</p> <p>4. Паркийн хөгжлийн Стратеги төлөвлөгөөний дагуу паркийн удирдлага засаглалыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд <Парк инновацич байгууллага> болох зорилгыг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p> <p>5. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журмын 3.4 /Паркийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн дагуу эрдэм шинжилгээ судалгаа явуулах нэгж, технологийн инкубатор төв байгуулах заалтын дагуу ХААИС, Ургамал хамгааллын эрдэм, шинжилгээний хүрээлэн, ШУТИС, ШАУИС-иудтай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулж дунд хугацааны төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p> <p>6. Мөн Паркийн инкубатор инноваци судалгааны төв /ПИИСТ/-ийг байгуулах төслийг боловсруулж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Эхний ээлжид ПИИСТ-ийн барилга, түүний засварын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.</p> <p>7. 2019 оны 03 дугаар сарын 22, 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрүүдэд БҮТП-д Биотехнологийг хөгжүүлэх нь уриан дор “Ховор эмийн ургамал, жимс жимсгэнэ тариалах нь” сэдэвт IV, V уулзалт зөвлөгөөнийг дүүргийн үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулан амжилттай зохион байгуулж, Хөх нуурын био станц, Хэрлэн баян-Улааны ховор эмийн ургамлын плантацитай танилцаж туршлага судлав. Тус арга хэмжээнд ХААИС, ШАУИС, УХЭШХ болон ШУҮ-ийн Монхимо ХХК-иудын төлөөллүүд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын илтгэл тавьж оролцсон.</p> <p>8. Паркад үйлдвэр байгуулах хүсэлтэй дараах байгууллагуудын мэдээллийг хүлээн авч паркийн эрх зүйн байдал, эзэмшил газар, дэд бүтцийн нөхцөлийн талаар санал солилцож, зөвлөгөө өгөв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • “Синкопа Монгол” ХХК-ны Нүүрсний химийн үйлдвэрийг байгуулах санал • “Очир Ундраа” ХХК-ны Багануурын уурхайн нүүрсээр тэсэлгээний бодис үйлдвэрлэх санал • “Хемп Монгол” ХХК-ны Эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал • Казахстан улсын “Эрдэс баялгийг иж бүрэн боловсруулах үндэсний төв” болон “Эко импаст” ХХК-ийн удирдлагаас Багануурын уурхайн нүүрс, шорооны хаягдлаас цахиурт хөнгөнцагааны хольц үйлдвэрлэх төсөл 	
--	--	--	--

		<p>хэрэгжүүлэх боломж байгаа талаар дүүргийн болон паркийн удирдлагад танилцуулав. Дараа нь уурхайн үйл ажиллагаатай танилцуулж, нүүрсний үнсний шинж чанарын мэдээлэл болон судалгааны зориулалтаар нүүрс шорооны холимгийн дээжийг авах ажлыг зохион байгуулав. Мөн "Монгол Минерал" ХХК, түүний түнш Герман улсын "PHARMAWERK" компанийн удирдлагуудад паркийн үйл ажиллагааг танилцуулан исэлдсэн нүүрсний гуминыг хүн болон мал эмнэлгийн эмчилгээнд ашиглах чиглэл, түүний нөөцийн асуудлаар санал солилцож Багануурын нүүрсний уурхай үйл ажиллагааг танилцуулав.</p>		
Дундаж хувь			96,66%	

ТАЙЛАН ХЯНАСАН:
 БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА  Ч.ЭЛБЭГСАЙХАН



БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Б.МИЧИД-ЭРДЭНЭ